

4-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН
ЖИШИГ ДААЛГАВАР

2019.05.01

40 минут

А хувилбар

1. Цээж бичиг Түүвэр өгүүлбэр
Хязгааргүй уудам далай тэнгис жижигхэн булгаас эхтэй байдаг. Цоохондой томрох тусмаа хониноос холдон ганцаараа явах нь олшрох болов. Арслан хулганыг базахын даваан дээр хулгана өршөөл эрэн гуйж ирэв. Тарвага газар доорх гэртээ унтана. Ном бол хүн төрөлхтний бүтээсэн гайхамшиг дундаас хамгийн дээд гайхамшиг нь юм. /Үг 43/
2. Өгүүлбэрийг гүйцээн тохирох үгийг нөхөн бичээрэй. Нөхөх үгс: (өрөг, өргө, болго, болог, хөөргө, хөөрөг)
Баруун гараа
Тоосго өрвөл
Хоолоо сайн
Бадрал алиалагч
Цаасан шувуугаа
Өвөөгийн том
3. Алдааг засаж бичээрэй.
Очрын ярихийг сонслоо. Ном уншхаар суулаа
4. Дараах үгсэд я, е, ё –г зөв залган бичээрэй.
Бод, харь, уя
5. Өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.
Захидал нь. , бүтэцтэй байдаг.

Б. Хувилбар

1. Цээж бичиг Баавгайг шийтгэсэн нь
Эрт урьдын цагт хөвчийн эзэн баавгай ойн амьтдын амар тайван амьдралд тун ч их саад болдог байжээ. Тэр аймшигтай чанга хурхирч, мод бутыг хуга гишгэж, шувууны үүрийг сүйтгэдэг байлаа. Амьтад тайгын эзний болхи бүдүүлэг байдлыг өөрт нь ойлгуулахыг хэчнээн оролдсон ч тэдний үгийг сонсохыг ч хүсдэггүй байлаа. Аргаа барсан амьтад түүнийг ойн шүүхэд өгчээ. Олны өмнө ийм эвгүй байдалд орж үзээгүй тэр ухаарч ичсэндээ нүүрээ хийх газаргүй болов. /Үг 66/
2. Өгүүлбэрийг гүйцээн тохирох үгийг нөхөн бичээрэй. Нөхөх үгс: (түвшин, төвшин, мэргэ, мэрэг, төлөг, төлгө)
Далайн ихсэв.
Төлөв зантай хүн.
Өвөөгийн маань үнэн.
Гөлөг минь яс дээ.
..... борлон болжмороос цочив.
Мэргэн хүн тавив.
Өвөөгийн том.
3. Алдааг засаж бичээрэй.
Хичээлээ бичхээр суулаа. Хаждын хайсан зүйлыг оллоо.
4. Дараах үгсэд я, е, ё –г зөв залган бичээрэй.
Зур, боль, оё
5. Өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.
Захидал нь. , хэлбэртэй байдаг.